Товьёг



| Д/д | Товч утга | Хуудасны тоо | Хуудасны дугаар |
|---|---|---|---|
| 1 | Засгийн газрын тогтоол | 7 | 2-8 |
| 2 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 1 | 8-9 |
| 3 | ХНХЯ-ны сайдын тушаал | 2 | 9-11 |
| 4 | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол | 1 | 11-12 |
| 5 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал | 10 | 12-22 |
| 6 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан даалгавар | 3 | 23-25 |

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭСТ
ХЯНАЛТАД АВСАН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ
2023 он

| Д/д | Зүйл заалтын дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга | Хэрэгжилтийн явц | Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал) | Тасарсан болон удааширч байгаа шалтгаан |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| Салбар чиглэл | | | | | |
| 1.Монгол улсын Засгийн газрын тогтоол | | | | | |
| 1 | | 2023.02.08 №60 “Журам шинэчлэн батлах тухай” | Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацааны НД-ын шимтгэл төлөх журмыг хэрэгжүүлэн ажиллаж үйл ажиллагаа явуулж буй 1425 ажил олгогчдын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд хяналт нийгмийн даатгалын цахим хяналт http://10.9.0.5/monitoring/, http://10.9.11.2:808/ndlav/ хянан баталгаажуулалт хийж 28886 даатгуулагчийн шимтгэлийн тооцооллыг хийж тайлан хүлээн авч ажилласан<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 2 | | 2023.03.15 №100 Журам жагсаалт заавар батлах тухай | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн үр нөлөөтэй цахим засаглалын төлөвшүүлэх зорилго зорилтын хүрээнд Нийгмийн даатгалын 34-н төрлийн үйлчилгээний 24-н үйлчилгээг нь цахимжуулсан бөгөөд E-Mongolia цахим системд 12 үйлчилгээг холбосон байна.<br>Төрийн үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг хангаж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дах хэсэгт заасан нээлттэй мэдээллүүдийг бүрэн байршуулан ажиллаж байна. https://orhon.ndaatgal.mn/personal-insurance/ цахим сайтад иргэд | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | даатгуулагчдад зориулсан маягт, гарын авлагуудыг нээлттэй байршууллаа.<br><br>Мөн тус хэлтэс нь Төрийн байгууллагын процессын дахин инженерчлэлийг хийж иргэд даатгуулагчид нэгээс илүү шат дамжлалгүйгээр төрийн үйлчилгээг нэг дороос авах нөхцөл боломжийн бүрдүүлсэн.<br><br>Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2023 оны А/09 тушаалаар “Үйлчилгээний стандарт” батлан мөрдөн ажиллаж байна.<br><br>Үүнээс гадна Нийгмийн даатгалын хэлтэс иргэдэд үйлчилгээ үзүүлж байгаа арга хэлбэрийг хялбаршуулах программ хангамжийг бий болгох цахимжуулах зорилгоор Ухаалаг ажлын байр, Роботын процесс автоматжуулалт, нийгмийн даатгалын байгууллагын процессын дахин инженерчлэл, Карте бүртгэлийн систем, Цахим архив, Ухаалаг архив, call center үйлчилгээ, чат бот үйлчилгээ, гүйцэтгэлийн удирдлагын live dashboard систем зэргийг хөгжүүлэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулсанаар дараах ач холбогдолтой байна. Нийгмийн даатгалын үйлчилгээ ил тод, түргэн шуурхай болох; Хүнд суртал, чирэгдэл багасаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх боломж бүрдэх, Нийгмийн даатгалын ажилтны ачаалал тодорхой хэмжээгээр буурч, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, таниулах ажилд цаг зарцуулах зэрэг ач холбогдолтой байна.<br><br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 3 | 14 | 2023.01.11 №15 Журамд өөрчлөлт оруулах тухай | “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн албан хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 3 дах хэсэгт 14 дэх заалт нэмснийг мөрдөн ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | | 2023 оны 03 сарын 01 №79 “Удирдамж батлах тухай” | Нийгмийн халамжийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалт хийсэн ажлын хэрэгжилт<br>Нийгмийн халамжийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтад урьдчилан сэргийлэх шалгалт хийх 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 07/09 дугаартай удирдамжийн дагуу халамжийн сангаас 2021 онд тэтгэвэр авч байсан 1607 иргэн, 2022 онд тэтгэвэр авч байсан 1929 иргэний (60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй ,16 нас хүрсэн одой иргэн, тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд) судалгааг хувийн хэрэгтэй нь тулган олголт тогтоолтын үндэслэлийг шалгах, асаргааны тэтгэмж авдаг 4456 иргэний судалгааг (2021-2022 оны) халамжийн программаас гаргуулан авч бүрдүүлэх материалын жагсаалт, асаргааны тэтгэмж авах иргэний оношийн заалт эмч эмнэлгийн ажилтны дүгнэлт болон асран хамгаалагчийн өргөдөл хүсэлт олгож эхэлсэн хугацаа хэр хугацаанд авч байгаа эсэх түүврийн аргаар зарим иргэдтэй нь багийн хэсгийн ахлагч, зохион байгуулагчтай хамтран явж уулзах байдлаар хянаж олгосон тэтгэмжийг программын олголт санхүүгийн тайлантай тулган шалгах, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн зарим үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн (Хүмүүн бие даан амьдрах төв ТББ, Архидалт мансуурлын эсрэг ассиоцаци ТББ, Хамтдаа тэмүүлэх гэрэлт ирээдүй ТББ, Аминчхан яриа ТББ, Ахмадын хороо НҮТББ, Улаан загалмайн хороо НҮТБ Байгууллагуудтай хамтран ажилласныг) ХНХГазартай байгуулсан гэрээ болон тайланд хамруулсан иргэдийн жагсаалтаас түүврийн аргаар өөртэй нь болон асран хамгаалагчтай нь утсаар холбогдож лавлан шалгах, мөн гарсан үр дүнгийн талаарх тайлантай уншиж танилцах, Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хувьд 2 онд нийт 4176 иргэнд олгосныг цаасан баримтуудыг олгосон тэтгэмжтэй нь цаг хугацааны хувьд болон давхардуулан олгосон | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | эсэхийг шалгах, Ахмад настны тухай хуулийн дагуу хөл гарын протезынг 5 жилд 1 удаа худалдан авсан, шүдний протезын үнийг 3 жилд 1 удаа олгосон ахмад настны (2021 онд 983, 2022 онд 1411) баримт бичгийн бүрдүүлэлт баримтууд болон Халамжийн сангаас шилжүүлсэн санхүүжилт, иргэний авсан хэрэгслийн тоо хэмжээ үнийн дүн нийцэж байгаа эсэхийг шалгах, Цалинтай ээжүүдийн 2021-2022 оны судалгааг (давхардсан тоогоор 6614 иргэн) хөрвүүлэн авч нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан хугацаатай давхардуулан олгосон эсэхийг хянан шалгах ажлыг хийж гүйцэтгэж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 5 | | 2023.02.08 №49<br>2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай | МУ-ын Засгийн газраас 2023 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан Нийгмийн даатгалын байгууллагын менежментийн чадавхыг бэхжүүлэх, иргэдийг эрсдэлээс хамгаалах, удирдлага, хяналтын тогтолцоог үр ашигтай, оновчтой зохион байгуулах, төрийн байгууллагад авлига бий болох шалтгаан нөхцөлийг арилгах, хууль эрх зүйн орчныг сайжруулах, төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх, хариуцлагыг чангатгах, шударга ёсыг бэхжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор олон улсын ISO 37001:2016 стандартад нийцсэн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлыг тус хэлтэс 2022 оноос эхлэн үе шаттайгаар, холбогдох стандартаар тогтоосон шаардлагын дагуу нэвтрүүлэн ажиллаж Монгол Улсын Төрийн байгууллага дундаа анх удаа хэрэгжүүлж 2023 онд Авлигын эсрэг ISO 37001:2016 стандартад нэвтрүүлж БНЭУ-ын олон улсын баталгаажуулалтын QFC байгууллагын батламж гэрчилгээг БНЭУ-ын Элчин сайдаас гардан авсан. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Жилийн эцсийн нийт 16 сурталчилгааны постер бэлтгэж, хөлтэй самбарт хийж, байцаагч ажилчдын ширээн дээр байрлуулах, хэлтсийн албаны вэб хуудас болон пэйж хаягт байрлуулан ажилласан.<br>Мөн авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулахаас гадна хэлтсийн 75776699 дугаарт залгаж, * хэсгээр холбогдох боломжтой болгож, сурталчлан таниулах постерууд бэлтгэсэн.<br>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн албаны пэйж хуудас болон вэб хуудсанд хавсралт 1-ийн постеруудыг байрлуулан нийт 181 хандалт хүлээн авсан байна.<br>Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй томоохон худалдааны төвүүдээр дамжуулан даатгуулагчийн өдөрлөг зохион байгуулж, давхардсан тоогоор 2090 иргэнд нөлөөллийн үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулан ажилласан.<br>Нийгмийн даатгалын хэлтсийн 1 давхарт Хаан банкны АТМ машины хажууд иргэд ихээр үйлчлүүлдэг газар АВЛИГЫН ЭСРЭГ ХАМТДАА самбар ажиллуулж мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 6 | 2.5 | 2023.04.05 №120 Шинжлэх ухаан технологийн салбарын авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай | Засгийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн Шинжлэх ухаан технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 120 дугаар тогтоолын 2.5 дах хэсэгт заасны дагуу Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг хэрэгжүүлэхэд чухал шаардлагатай Мэдээллийн технологийн мэргэжилтэн, сүлжээний инженер хариуцсан ажилтныг тогтвор суурьтай ажиллуулах, мэргэжил боловсролыг дээшлүүлэх, сургалтын хөтөлбөрийг боловсруулан гаргах, сургалтын холбогдох зардлыг байгууллагын | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | зүгээс гаргах, сурах нөхцөл боломжоор хангах бодлого баримтлан ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 7 | | 2023.05.31 №213 Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр түүнийг хэрэглэх төрийн байгууллагын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай | Хэлтсийн даргын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/22 тоот тушаалаар Тус хэлтсийн Мэдээллийн технологи хариуцсан ажилтныг Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах ТҮ-7 зэрэглэлд хамааруулан ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 8 | | 2023 оны 08 дугаар сарын 23 №301 Журам шинэчлэн батлах тухай | Монгол улсын засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоол гарсантай холбоотойгоор Хэлтсийн даргын А/23 тушаалаар Хэлтсийн үнэлгээний багийг шинэчлэн байгуулж 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам” сэдэвт сургалтыг Хэлтсийн үнэлгээний багаас зохион байгуулж сургалтад тус хэлтсийн 36 албан хаагч хамрагдсан бөгөөд тус журмыг баримтлан ажиллаж байна.<br>Мөн Монгол улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны Аргачлал загвар батлах тухай №98 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг шинэчилсэн загварын дагуу тайлагнаж, аргачлалын дагуу үнэлж дүгнэн ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 9 | | 2023 оны 09 дүгээр сарын 26 №362 Дүрэм батлах тухай | Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн “Дүрэм батлах тухай” 362 дугаар тогтоолоор Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн дүрмийг 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Гомдлын шаардлагын зөвлөлийн 5 гишүүдэд уншиж, танилцуулж ажилласан.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | | 2023.06.21 №238 Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай | Тэтгэвэр тогтоолгосон дундаж цалинтай 13097 тэтгэвэр авагчийн дундаж цалинг итгэлцүүрээр өсгөн тэтгэврийг олгосон. Дундаж цалингийн хэмжээ 25.8 хувиар, авч буй тэтгэврийн хэмжээ 75.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Итгэлцүүр шинэчлэн батлагдсантай холбогдуулан 6 иргэн дундаж цалинд авч байгаа хязгаарын хэмжээг бага байна гэсэн өргөдөл ирүүланийг тухай бүр тайлбарлан, шийдвэрлэж ажиллав.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 11 | | 2023.06.21 №239 Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай | Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай МУЗГ-ын 239 дугаар тогтоолын дагуу Хэлтсийн даргын А/21 дүгээр тушаалаар ажлын хэсэг гарч 17581 тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тогтоолтын хуудсыг хэвэл баталгаажуулж, мэдээллийн баазад хадгалан, тэтгэврийг хуулийн хугацаанд олгож ажилласан. Орхон аймагт дундаж тэтгэвэр 28.8 хувиар, дээд хэмжээ нь 98.6 хувиар тус тус нэмэгдсэн. Одоогоор аймгийн дундаж тэтгэврийн хэмжээ 798.5 мянган төгрөг байна. Тэтгэврийн нэмэгдэлтэй холбоотой иргэдээс гомдол, санал гараагүй болно.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| *Хэсгийн дундаж хувь: 100%* | | | | | |
| 2.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | | | | | |
| 1 | | 2023.01.25-ны өдрийн ЗГ-ын 5 дугаар хуралдааны тэмдэглэл: “МУ-ын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон МУ-ын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн 2022 оны хэрэгжилтийн тухай | Тус хуралдааны 3 дахь хэсэгт заасны дагуу Төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зорилго зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулахдаа өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээ, үйл ажиллагаа тэдгээрийн тухай оны хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг урьдчилан тодорхойлж, байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган ажиллаж Нийгмийн даатгалын Ерөнхий газрын арга хэмжээ, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан 5 зорилт 54 арга хэмжээ төлөвлөн ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 2 | | 2023.02.01-ний өдрийн ЗГ-ын хуралдааны 06 дугаар тэмдэглэл: Судалгааны сан түүний нэгдсэн системийн бүрдүүлж буй ажлын явцын талаар | 2023 онд зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажил арга хэмжээ байхгүй бөгөөд тус хэлтэс нь дотооддоо иргэд даатгуулагчдаас сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Сэтгэл ханамжийн судалгааны тайланг сар, улирлаар гарган нэгтгэж Нийгмийн даатгалын хэлтсийн цахим хуудсаа тогтмол байршуулж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 3 | | 2023.03.29-ний өдрийн 14 дүгээр тэмдэглэл<br>МУ-ын Ерөнхий сайд МУ-д үйл ажиллагаа явуулж байгаа ОУ-ын байгууллагын ажилтнуудтай хийсэн уулзалтын талаар | Тус хуралдаанд МУ-ын Ерөнхий сайд Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа ОУ-ын байгууллагын ажилтнуудтай хийсэн уулзалтын талаар Засгийн газрын гишүүдэд танилцуулж дараах арга хэмжээг авч ажиллахыг даалгасан бөгөөд Үүнд:<br>1. Олон улсын байгууллагын санхүүжилтийн хэрэгжүүлэх төслийн хүрээнд төрийн албан хаагчдын мэргэшүүлэх зорилгоор гадаад улсад туршлага судлах, аялалд хамруулах арга хэмжээ авах<br>2. Гадаад улсад магистр, доктор болон ахисан түвшний сургалтад хамрагдсан албан хаагчдыг ажлын байранд эргүүлэн томилох зэрэг чиглэл өгснийг тус хэлтэс хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>2022-2023 оны жилийн эцсийн байдлаар нэг албан хаагч АНУ-д 6 сарын хугацаатай, Австрали улсад нэг албан хаагч 2 сарын хугацаатай мэргэжил дээшлүүлсэн бөгөөд 2023 оны 06, 07 саруудад Төрийн бүтээмжийн чиглэлээр Сингапур болон Тайвань улсад богино хугацааны сургалтад 2 албан хаагч хамрагдахаар болсон байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| *Хэсгийн дундаж хувь: 100%* | | | | | |
| 3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | | 2023.01.02 А/01 "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" | ХНХЯ-ны сайдын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 тоот тушаал, НДЕГ-ын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04/179 шийдвэрийг нэг цэгийн байцаагч болон тэтгэврийн байцаагч холбогдох ажилтанд танилцуулан ажил олгогч, даатгуулагч нарт хэлтсийн цахим хуудсаар дамжуулан мэдээллээр хanган батлагдсан өдрөөс эхлэн хэрэгжүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 2 | | 2023.01.19 А/06 "Мэргэшлийн зэрэг олгох тухай" | Хөдөлмөр Нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/06 дугаар тушаалаар "тэргүүлэх" зэрэг олгогдсон байцаагч ажилтнуудад Хэлтсийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн Б/10 тоот тушаалаар зэргийг нэмэгдлийг 10% олгож байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 3 | | 2023.10.25 А/136 "Тэтгэвэр тогтоолгох үндсэн ажил, мэргэжлийн жишиг цалин батлах тухай" | Тэтгэвэр тогтоолгох үндсэн ажил, мэргэжлийн жишиг цалин батлах тухай ХНХСайдын тушаалыг хэлтсийн байцагч нарт танилцуулан мэдээлэл хүргэж ажилласан.<br>Шинэчлэгдэн батлагдсан жишиг цалинг үндэслэн тэтгэврийн хэмжээг тооцуулах хүсэлт 13 иргэнээс ирсэн бөгөөд 6 иргэний тэтгэврийн хэмжээ өөрчлөгдөн 35.5 хувиар өссөн.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | | 2023.10.02<br>Гадаад харилцааны сайд, ХНХЯ-ны сайдын хамтарсан тушаал А/69, А/132<br>Монгол улсаас хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газрын ажилтны адилтгах албан тушаалын жагсаалт нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах жишиг цалин хөлсний хэмжээг батлах тухай | Гадаад харилцааны сайд, ХНХЯ-ны сайдын хамтарсан тушаал А/69, А/132 тушаалыг хэлтсийн албан хаагчдад танилцуулан ажилласан. Орхон аймагт тухайн төрөлд тайлагнадаг даатгуулагч байхгүй байна<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| *Хэсгийн дундаж хувь: 100* | | | | | |
| 4.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол | | | | | |
| 1. | | 2022.12.28 №07 “Нэрийн дансны 2022 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 07 дугаар тогтоол “Нэрийн дансны 2022 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” НДЕГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04/162 тоот “Шийдвэр хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу 2022 оны орлогод тооцох хүүгийн хэмжээ 9.8 хувь болсныг байцаагч ажилтан болон иргэд даатгуулагчдад Нийгмийн даатгалын цахим дэвтэр, нийгмийн даатгалын апликэйшн, нийгмийн даатгалын цахим хуудас, E-mongolia зэргээс харах татах боломжтой зэрэг мэдээлэл хүргэн хэрэгжүүлэн ажилласан.<br>2023 оны жилийн эцсийн байдлаар өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 658 иргэдээс нэрийн дансны аргаар тооцуулан тогтоолгох хүсэлт гаргасан иргэн гараагүй бөгөөд, бүгд 7 жилийн цалин хөлсний дунджаар тэтгэврээ тогтоолгох хүсэлт гаргасан байна. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | *Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 2. | | 2023.07.05 №05<br>2023 оны тодотгосон төсвийн хуваарь батлах тухай | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 05 дугаар тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны А/105 тушаалаар батлагдсан “2023 оны тодотгосон төсвийн сар, улирлын хуваарь батлах тухай” тушаалын дагуу нийгмийн даатгалын сангийн сар, улирлын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж ажиллаж байна. Энэхүү хуваарьт 2023 оны нийгмийн даатгалын сангийн орлого 5.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, сангийн зардал 18 тэрбумаар нэмэгдсэн дүнтэй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор дундаж цалин хөлс нэмэгдсэн, мөн тэтгэврийг итгэлцүүр хэрэглэн дахин тогтоох үйл явцаас шалтгаалж нэмэгдсэн байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| *Хэсгийн дундаж хувь:* | | | | | |
| 5.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал | | | | | |
| 1 | | 2022.12.13 А/184 “Үндсэн хөрөнгийг данснаас хасаж, ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох тухай” | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 521 дүгээр тогтоол, НДЕГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/184 тоот тушаалын дагуу Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор 40,970,667 төгрөгийн машин, тоног төхөөрөмжийг данснаас хасаж, ашиглалтын хугацааг 1 жилээр сунган 8,194,128 төгрөгөөр тайланд тусган үнийг шинэчлэн тогтоосон. Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд бүртгэж, биелэлтийг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 196 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 2 | | 2022.12.30 А/193 “Үндсэн хөрөнгө актлах тухай” | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 695 дугаар тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/193 тоот тушаалын дагуу Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 23,374,825 төгрөгийн машин, тоног төхөөрөмж, | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 3,687,400 төгрөгийн тавилга эд хогшлыг данснаас хасаж тайланд тусган, Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд бүртгэж, биелэлтийг 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 196 тоот албан бичгээр хүргүүлсэн. *Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 3 | | 2023.01.10 №А/01 2023 оныг Нийгмийн даатгалын шинэчлэлийн жил болгон зарлах тухай | Нийгмийн даатгалын Ерөнхий газраас 2023 оныг "Нийгмийн даатгалын шинэчлэлийн жил" болгон зарласантай холбогдуулан тус хэлтэс 5 зорилт 37 арга хэмжээ төлөвлөн ажиллаж биелэлтийг жилийн эцсийн хугацаанд тайлагнан ажиллалаа. *Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 4 | | 2022.12.30 А/194 "Тоног төхөөрөмж, программ хангамж хуваарилах тухай" | Тушаалын дагуу хөрөнгө хүлээн авсан анхан шатны баримтуудыг бүрдүүлэн санхүүгийн программ болон Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд бүртгэн тайланд үнэн зөв тусгасан. Тоног төхөөрөмжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллаж байна. *Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 5 | | 2023.01.24 А/16 "Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө биелүүлэх, шимтгэлийн авлага барагдуулах тухай" | Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулж хамрагдах хүний тоо, орлогын төлөвлөгөөг төсвийг хуваарийг дагуу биелүүллээ.<br><br>Нийгмийн даатгалын сангийн орлогын сар, улирал бүрийн төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллаж 2023 оны жилийн эцсийн байдлаар 170.796,3 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулахаас 175.066,2 сая төгрөгийн шимтгэлийн орлого оруулж 102.5 хувийн биелүүлсэн.<br><br>"Нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх, хамралтыг нэмэгдүүлэх ажлын нэгдсэн удирдамж" -ын дагуу 40 аж ахуй нэгж байгууллагын 2.0 тэрбум төгрөгний гэрээ байгуулж, үүнээс 33 аанб-ын 1960.7 сая төгрөгний өр авлагыг барагдуулан ажиллаж байна. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | | | Мөн ААНБ-ын шимтгэлийг сар бүр төлүүлэх, шинээр өр авлага үүсгэхгүй байх, өмнөх онуудын шимтгэлийн авлагын судалгааг насжилтаар гарган барагдуулж, эзэн холбогдогч тодорхойгүй болсон татан буугдсан зэрэг ААНБ-ын судалгааг гарган Цагдаагийн газар, ШШГазартай хамтран ажиллаж өр, авлагыг буруулан ажиллаж мэдээг холбогдох хэлтэс газарт долоо хоног бүрийн 2 дахь өдөр, сар бүрийн 15-нд хүргүүлэн ажиллаж байна. | | |
| 6 | | 2023.01.18 А/07 “Төлөвлөгөө батлах тухай” | Жаргалант Баян-өндөр сумын 279 малчин өрхөөр орж 394 иргэнд Нийгмийн даатгалын тухай хууль, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль, 0-3 хүртэлх настай хүүхэдтэй ээжийн сайн дурын даатгалыг хөнгөлөх тухай, хүүхдийн тоогоор 1 жил 6 сар нэмэх тухай, сайн дурын даатгалын тухай мэдээллийг нийт 3088 км явж 185 хуудас тараах материал хүргэн ажиллалаа.<br>• Их дээд сургуулийн оюунтан, ерөнхий боловсролын сургуулийн ахлах бүлгийн сурагчдад хийсэн даатгалтай ирээдүй сургалтаар 11 сургуулийн 325 оюутан сурагчдад мэдээлэл түгээлээ.<br>• Тус хэлтэс нь 5.6.10 дугаар сард даатгуулагчийн өдөрлөгийг зохион байгуулах хуваарьтай бөгөөд хуваарийн дагуу 5 сард 6 томоохон худалдаа үйлчилгээний төвүүд болон талбай дээр даатгуулагчийн өдөрлөгийг зохион байгуулж уг өдөрлөгөөр 361 иргэд даатгуулагчдад зөвлөгөө үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.<br>ЭХМК-ийн хурлаар орж хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгож буй иргэдэд нийт 20 удаагийн хурлаар 1370 иргэнд мэдээлэл хүргэн ажилласан байна.<br>• Энэ оны жилийн эцсийн байдлаар 21 удаагийн шууд бичлэг хийж үүнийг 38 892 /давхардсан тоогоор/, 69 удаагийн постероор 501 327, чатаар 15508, гаднаас ирсэн дуудлагад 9445, хамрагдалт | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | нэмэгдүүлэх зорилгоор гадагш чиглэсэн дуудлага 2080 дуудлага тус тус хийсэн байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 7 | | 2023.02.06 А/22 “Бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай” | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/22 тушаалаар бүрэлдэхүүн шинэчлэн баталсан. Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Гомдлын шаардлагын салбар зөвлөл нь шинэчлэн батлагдсан бүрэлдхүүнээр иргэд даатгуулагчдаас ирсэн гомдол хүсэлтыг хүлээн авч цаг тухай бүрт нь хуралдаж ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар 5 удаа хуралдаж 18 иргэний асуудлыг шийдвэрлэж ажиллалаа.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 8 | | 2023.03.13 А/29 “Нээлттэй дуудлагын худалдаа зохион байгуулах тухай” | Капитал банкны өр төлбөрт суутгасан хөрөнгийг нээлттэй дуудлага худалдаа зохион байгуулах 2023.03.16-ны өдрийн №05/510 албан бичгийн дагуу мэдээлэл түгээх 4 постер хийж, хэлтсийн фэйж хуудсанд байршуулж, 10300 хүнд мэдээллийг хүргэж ажилласан. Дуудлага худалдаа 04 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 9 | | 2023.03.03 А/27 “Ажлын хэсэг байгуулах тухай” | Капитал банк ХХК дах Банкны эрх хүлээн авагчаас нийгмийн даатгалын сангийн нэхэмжилсэн өр төлбөрт хүлээн авсан хөрөнгүүдийг Монгол улсын иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам” Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 18 дугаар тогтоол болон холбогдох бусад хууль тогтоомжийг тус тус үндэслэн 2023 оны 3 дугаар сарын 01-ны өдөр Баян-Өндөр сумын 6-р баг, Согоот 6-р хороолол 22 байр-19 тоот, 45 м.кв талбайтай, 1 өрөө байрыг НДЕГ-тай хувь хүн түрээсийн гэрээ байгуулсны дагуу түрээслүүлэн ашиглаж байна. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10 | | | Тухайн байрны хэрэглээний зардал төлөгдөж эхэлсэн тул өр төлбөргүй байна.<br>Баян-Өндөр сумын 6-р баг, Согоот 6-р хороолол 22 байр-02 тоот, 52 м.кв талбайтай, 2 өрөө байр нь түрээслүүлэх, худалдан борлуулаагүй одоогийн байдлаар хоосон байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 10 | | 2023.03.20 А/35 “Төлөвлөгөө батлах тухай” | Авлигын эсрэг менежментийн тогтолцоо MNS ISO 37001:2016 стандарт хэрэгжүүлэх ажлын хэсгийн 2023 оны хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө хэлтсийн даргаар батлуулж, батлагдсан төлөвлөгөөний дагуу ажлууд хийгдэж, хийж гүйцэтгэсэн ажлын тайланг холбогдох газруудад цаг хугацаанд нь хүргүүлж ажиллаж байна. Жилийн эцсийн ажлын тайланг хавсралтаар хүргүүлэв.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 11 | | 2023.03.27 А/39 “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” | Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2018 оны Бүтэц орон тоо батлах тухай А/22 тоот тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан албан тушаалын жагсаалтад Сан хариуцсан мэргэжилтэн, Сүлжээний инженер гэсэн албан тушаалын нэршлийг шинээр нэмж “Магадлагч эмч Тэтгэмжийн хяналтын байцаагч” гэсэн нэршлийг “Магадлагч эмч” гэж өөрчилсний дагуу хэлтсийн даргын 2023 оны А/11 тоот тушаалаар тус тусын Ажлын байрны тодорхойлолт батлан ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 12 | | 2023.04.07 А/17<br>Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай. | Тус хэлтсийн дарга Б.Анар Улаанбаатар хотод шилжин ажиллах болсонтойгоор Орхон аймгийн ЭХМК-ын даргаар Д.Нармандах томилогдон аймгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадалгаа тогтоох ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд зохион байгуулан, ажлын үр дүнг тооцож ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 13 | | 2023.04.07 А/47 “Сургалт зохион байгуулах тухай” | Нийгмийн даатгалын салбарын архив, албан хэрэг хөтлөлт, хүний нөөцийн талаар тулгамдаж буй асуудлаар санал солилцох, зөвлөлдөх, үйл ажиллагааны үр дүнг хэлэлцэх, цаашид анхаарах асуудлын талаарх мэргэжил арга зүйн сургалтад 2023 оны 04 дүгээр сарын 13,14-ний өдрүүдэд Архивын ажилтан Н.Намуундарь, Хүний нөөцийн ажилтан Д.Идэржавхлан нар Нийгмийн даатгалын Ерөнхий газарт доорх хөтөлбөрийн дагуу хамрагдлаа.<br>• Нийгмийн даатгалын салбарын хүний нөөцийн бодлого, архив албан хэрэг хөтлөлт, сургалтын ач холбогдол<br>• Архив, албан хэрэг хөтлөлт<br>• Баримт бичгийн стандарт<br>• Архивд материал хүлээлгэн өгөх, стандартын дагуу архивын материал бэлтгэх<br>• Байгууллагын бичиг хэргийн стандарт, түгээмэл гаргаж буй алдаа сайжруулах арга зам<br>• Өнөөгийн байдал ба тулгамдаж буй асуудал түүнийг шийдвэрлэх нь<br>• Сургалтын дүгнэлт, цаашдын зорилт, анхаарах асуудлыг нэгтгэн танилцуулах Төрийн болон албаны нууцын тухай<br>• GREEN ERP HR системийн ашиглалт<br>• Харилцаа хандлага чөлөөт сэтгэлгээ<br>• GREEN ERP HR системтэй холбоотой гарч буй алдаа түүнийг засварлах<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 14 | | 2023.03.21 А/36 “Даатгуулагчийн төрлийн код шинээр батлах тухай” | Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан 1425 ажил олгогчийн 6810 удаагийн тайланд хяналт тавин ажиллаж 72,73 төрлөөр тайлагнах ажил олгогч бүртгэгдээгүй байна. Төрөл кодын өөрчлөлтийн талаар байгууллагад аж ахуйн нэгж байгууллагад мэдээлэл хүргэн ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 15 | | 2023.04.07 А/43 “Даатгуулагчийн төрлийн код шинээр батлах тухай” | ХНХСайдын 2020 оны 246/а/245 дугаар тушаалыг хэрэгжүүлэн ажиллаж Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд 1425 даатгуулагчийг 06 төрлөөр, 2 даатгуулагчийг 32 төрлөөр бүртгэн | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | мэдээллийн баазад оруулж тайлагналаа. Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй бүртгэлтэй идэвхтэй тайлан ирүүлдэг 1425 аанб д 06,32 төрөл кодын нэршлийн өөрчлөлтийн талаар мэдээлэл түгээж нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан хүлээн авч хэрэгжүүлэн ажиллалаа.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 16 | | 2023.04.17 А/49 “2023 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” | 2023 онд 895.3 сая төгрөгийн үйл ажиллагааны төсөв батлагдаж ирсэн ба батлагдсан төсвийг ангилал, зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, төсвийн сахилгыг ханган төрийн хэмнэлтийн хуулийг баримтлан ажиллаж байна.<br><br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 17 | | 2023.03.14 А/33 “Журам хүчингүй болгох тухай” | “Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагуудын автомашин ашиглалтын журам”-ыг хүчингүй болгох тушаалыг хэрэгжүүлэн, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу үйл ажиллагаандаа санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 18 | | 2023.04.18 А/56 “Аймаг, дүүргүүдэд зохион байгуулах сургалтын төсвийн хуваарь батлах тухай” | Иргэд, даатгуулагчид, малчид, ХХЭ-д зориулсан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХАБЭА-н чиглэлээрх сургалтыг мэргэжлийн сургалтын байгууллагуудтай хамтран орон нутагтаа зохион байгуулахыг нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт үүрэг болгосны дагуу Хэлтсийн даргын 2023 оны А/15 тоот тушаалаар тус хэлтсийн 7 байцаагч, саналын эрхгүй 1 байцаагч /нарийн бичиг/, мөн “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, ХАБЭА-н сургалт зохион байгуулах сургалтын байгууллага сонгон шалгаруулах журам”-д заасны дагуу ХХҮГ-тай зөвшилцөж Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Ж.Баяржаргал, Г.Батцэнгэл нарын оролцуулан ажлын хэсгийг журмын дагуу томилсон. Ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу 7 | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | сард байгууллагыг сонгон шалгаруулж, тайлан мэдээг 11 дүгээр сард НДЕГ-т хүргүүлэхээр ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 19 | | 2023.05.24 А/78 Заавар батлах тухай | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Заавар батлах тухай” А/78 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулахад баримтлах заавар”, “Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлын болон туслах үйл ажиллагааны орлогын төсвийн төсөл, төсөөлөл боловсруулахад баримтлах заавар”-ыг баримтлан 2024 оны төсвийн төсөл, 2025, 2026 оны төсвийн төсөөллийг боловсруулан ажилласан.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 20 | | 2023.06.06 А/86 “Аудитын зөвлөмж хэрэгжүүлэх тухай” | 2023.06.07 №05/1177 албан бичиг эйблээр цохогдсон<br>ЭМНДЕГ-ын даргын 2017 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг үүссэн хугацаагаар нь ангилах, хянан шийдвэрлэх журам”-ын дагуу шимтгэлийн авлагыг бууруулах чиглэлээр шат дараалсан арга хэмжээ авах ажлыг эрчимжүүлэн<br>Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагыг барагдуулахад шат дараалласан арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:<br><br>**<u>Уулзалтаар</u>** – 695 ААНБ-ын 3112.3 сая төгрөгийн өр авлагыг талаар уулзалт хийсэн бол 333 ААНБ-ын 2259.6 сая төгрөгийг барагдуулан ажилласан. БИЕЛЭЛТ – 72.6%<br><br>**<u>Хуваарь, гэрээ байгуулж</u>** – 40 ААНБ-тай 2027.7 сая төгрөгийн авлага бууруулах хуваарь байгуулсан бол үүнээс 33 ААНБ-ын 1960.7 сая төгрөгийн авлагыг бууруулан ажилласан. Хуваарийн дагуу төлөлт хийгээгүй хүлээсэн хариуцлагаа хуулийн хугацаанд | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | биелүүлээгүй ААНБ-ыг дараагийн шатны арга хэмжээрүү шилжүүлэн ажиллаж байна. БИЕЛЭЛТ – 96.6%<br>**<u>Данс хаасан</u>** – 112 ААНБ-ын 1,895.3 сая төгрөгийн авлагатай холбоотойгоор ААНБ-ын харилцах данс хааснаар 22 ААНБ-ын 459.2 сая төгрөгийн авлагыг бууруулан ажилласан байна. БИЕЛЭЛТ – 24.2%<br><br>**<u>Албан шаардлага</u>** - 49 ААНБ-ын 1765.6 сая төгрөгийн авлагад шаардлага хүргүүлснээр 41 ААНБ-ын 371.1 сая төгрөгийн авлага барагдуулсан байна. БИЕЛЭЛТ – 21%<br>**<u>Шүүхэд шилжүүлсэн</u>** – Өмнөх онуудад шүүхэд шилжсэн 26 ААНБ-ын 1.803,2 сая төгрөгийн авлага байгаагаас 379,5 сая төгрөгийн авлага барагдуулан ажилласан байна. БИЕЛЭЛТ – 21%<br><br>Өмнөх оны хуримтлагдсан өр авлагыг 2.163,4 сая төгрөгөөр барагдуулан нийт авлагын 51.5 хувийн гүйцэтгэлтэй ажилласан боловч тус онд шинээр 3.225,6 сая төгрөгийн авлага үүссэн байна. Авлага барагдуулах ажлыг шат дараатайгаар авч тус оны эцэст 60 хувийн биелэлттэй ажиллахаар зорьж байна. Авлага барагдуулах ажлыг шат дараатайгаар авч тус оны эцэст 60 хувийн биелэлттэй ажиллахаар зорьж байна.<br><br>Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны нэгдсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийгдсэн.<br>Дүгнэлтээр анхан шатны баримтгүй 0.8 сая төгрөгийн зарлага гаргаж зарцуулсан тул 1 акт, төрийн хэмнэлтийн тухай хууль төсвийн тухай хуулийг зөрчиж байгууллагын тээврийн хэрэгслийг хэрэглэж 0.8 сая төгрөгийн шатахуун зарцуулсан, мөн өмнөх оны зөвлөмж санхүүгийн тайлангийн тодруулгыг зохих журамд нийцүүлж тайлагнаагүй зөрчил илэрсэн. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 21 | | | Мөн өмнөх оны зөвлөмж насжилт ихтэй авлагыг барагдуулаагүй гэсэн зөвлөмж авч биелэлтийг 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор шийдвэрлэж хариу хүргүүлэхээр ажиллаж байна. Одоогоор насжилт ихтэй сангийн бусад өр авлагыг судалж 2022 оны эцсийн үлдэгдэл 66.6 сая байсныг тайлант хугацаанд 20 сая төгрөгөөр барагдуулж ажилласан байна. *Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 21 | | 2023.01.06 А/04 “Төсвийн орлогын сар, улирлын хуваарийг батлах тухай” | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн “2023 оны төсвийн хуваарь батлах батлах тухай”2022 оны 06 дугаар тогтоолын дагуу Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар бүр жигд ханган биелүүлж жилийн эцсийн байдлаар 116% буюу 16 хувиар орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна. *Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 22 | | 2023.07.07 А/105 дугаар тушаал 2023 оны тодотгосон төсвийн сар улирлын хуваарь батлах тухай | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 05 дугаар тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны А/105 тушаалаар батлагдсан “2023 оны тодотгосон төсвийн сар, улирлын хуваарь батлах тухай” тушаалын дагуу нийгмийн даатгалын сангийн сар, улирлын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж ажиллаж байна. Энэхүү хуваарьт 2023 оны нийгмийн даатгалын сангийн орлого 5.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, сангийн зардал 18 тэрбумаар нэмэгдсэн дүнтэй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор дундаж цалин хөлс нэмэгдсэн, мөн тэтгэврийг итгэлцүүр хэрэглэн дахин тогтоох үйл явцаас шалтгаалж нэмэгдсэн байна. Хэлтсийн үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн сар, улирлын хуваарьт цэвэр, бохир усны зардлаас хэмнэгдсэн 2,6 сая төгрөг гэрэл цахилгаан, бичиг хэргийн зардлын ангилалд шилжүүлэх саналын дагуу өөрчлөн батлагдсан ба төсвийг ангилал, зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, төсвийн | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | сахилгыг ханган төрийн хэмнэлтийн хуулийг баримтлан ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 23 | | 2023.06.14 №А/90 Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай | Хэлтсийн үйл ажиллагааны урсгал зардлын тодотгосон төсвийн сар, улирлын хуваарь төрийн албан хаагчийн цалингийн шатлал өөрчлөгдсөнтэй холбоотой цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардал 222,5 сая төгрөгөөр нэмэгдэж батлагдсан ба төсвийг ангилал, зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, төсвийн сахилгыг ханган төрийн хэмнэлтийн хуулийг баримтлан ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 24 | | 2023.06.14 №А/92 дугаар тушаал<br>Журам шинэчлэн батлах тухай | Нийгмийн даатгалын байгууллагын эд хөрөнгийн тооллого явуулах журмын дагуу хэлтсийн 2023 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн А/19 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг ажиллаж тооллогын дүн мэдээг хугацаанд нь хүргүүлсэн. Мөн элэгдлээрээ анхны өртгөө нөхөж цаашид ашиглах боломжгүй болсон актлах хөрөнгө болон ашиглалтын хугацаа үнэ шинэчлэн тогтоох хөрөнгийн жагсаалтыг гарган ӨХБЗ-д танилцуулж саналыг НДЕГ-т хүргүүлэн ажилласан.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 25 | | 2023.04.26 №А/59 дугаар тушаал Журамд нэмэлт оруулах тухай | НДЕГ-ын даргын 2023 оны А/59 дугаартай “Журамд нэмэлт оруулах тухай” тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Гэр бүлийн батлахгүй 11 даатгуулагчид тэжээгчээ алдсаны тэтгэврийг тогтоон хуулийн хугацаанд хэвийн олгож байна. Шинээр тогтоож байгаа тэтгэврийн материал бүрд жил нөхөн тооцуулсан “Баталгаажилтын хуудас”-ын үндэслэлийг шалгаж, 2020-2023 онуудад малчин нөхцлөөр тэтгэвэр тогтоосон 113 тэтгэвэр авагчийн жил нөхөн | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | тооцуулахдаа бүрдүүлсэн баримтын үндэслэлийг шалгаж, тэтгэврийн хувийн хэрэгт хуулбарлан хавсаргаж ажиллав. *Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 26 | | 2023.07.05 №А/101 Төсвийн шууд захирагч нарт үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох тухай | Төсвийн шууд захирагчийн 2023 оны 1, 2-р улирлын гүйцэтгэлийг харгалзан үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох тушаалын дагуу 870,926 төгрөгийн урамшууллыг 07 дугаар сард олгосон. *Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 27 | | А/147 Журам батлах тухай | “Нийгмийн даатгалын Сангийн төсвийн гүйцэтгэл санхүүгийн тайлан хүлээн авах хянах баталгаажуулах журам”-ын дагуу нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг хийж гүйцэтгэж байна. Төсвийн гүйцэтгэлийн тайланг нийгмийн даатгалын цахим системээр, санхүүгийн тайланг “Засгийн газрын санхүүгийн Э-Тайлан” цахим системээр хууль, журамд заасны дагуу тус тус илгээсэн байна. *Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 28 | | 2023.05.26 А/82 Зарим норматив хүчингүй болгох тухай | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/82 дугаар тушаал, 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 01/1081 тоот албан бичгийн дагуу Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн байгууллагын автомашиныг ашиглахгүй байгаа бөгөөд хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлсэн болно. *Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| Хэсгийн дундаж хувь 100 | | | | | |
| | | | | | |
| 7. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан даалгавар | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | | 2022.12.14 №02 Ажил эрчимжүүлэх, ажлын бүтээмжийг дээшлүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай | НД-ийн байгууллагын бүтээмжийг дээшлүүлэх, байцаагч ажилтнуудын сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр 7 заалтын хүрээнд ажил арга хэмжээ зохион байгуулж ажиллаж байна. Ажилтан албан хаагчдын цаг ашиглалт бүтээмжийг дээшлүүлэх, үр дүнд тавих хяналтыг сайжруулах зорилгоор албан хаагчдын ирцийн бүртгэлийг өдөр бүр бүртгэж гадуур ажиллах тухай бүрд гадуур ажлын дэвтэрт тэмдэглэл хөтлөн ажиллаж байна.<br>Албан хаагчид, ажиллагсдад гэр бүлийн гачигдал тохиолдох буюу хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар цалинтай болон цалингүй чөлөө олгох асуудлыг хэлтсийн дарга шийдвэрлэж чөлөө авах шалтгаан, нөхцөл байдал, давтамж, ажлын ачаалал, цаг үеийн байдлыг харгалзан ажлын 1 өдөр хүртэл буюу 8 цаг хүртэлх чөлөөг тасгийн дарга, түүнээс дээш хугацаагаар олгох чөлөөг хэлтсийн дарга олгож, Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн бүртгэлжүүлэн ажиллаж байна.<br>Албан хаагчдын цалинтай, цалингүй чөлөө, гачигдал болон өвчлөлийн байдалд сар бүр судалгаа шинжилгээ хийж ажиллаж байна. Нийгмийн даатгалын хэлтсийн үйлчилгээний танхимыг Хэлтсийн байрны нэг давхарт шилжүүлснээр өндөр настай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчилгээ авахад хялбар болсны дээр төрийн үйлчилгээний шат дамжлага буурч нийгмийн даатгалын бүх төрлийн үйлчилгээг нэг дороос авах боломжийг бүрдүүлсэн. Нийгмийн даатгалын дугаар дуудах үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн оочир дараалалгүйгээр үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлж зориулалтын ширээ сандалд тусгай үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.<br>Үйлчилгээний стандартын дагуу гэрэлтүүлэг бүхий тааз, нийгмийн даатгалын үйлчилгээний талаарх мэдээллийг иргэдэд нээлттэй, ил тод, түргэн шуурхай хүргэх үүднээс мэдээллийн | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | самбар, даатгуулагчийн буланг шинэчлэн байршуулж, иргэд даатгуулагчдын тохь тухтай байх орчныг бүрдүүлж хүлээлгийн танхимд Ус шүүгч шинээр байршуулж даатгуулагчид хүлээлгийн танхимд цай, коффе уух нөхцөл боломжийг бүрдүүлсэн.<br>Мөн 1 давхарт хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан зориулалтын 00 тохижуулсан. Тус хэлтэс нь Авлигын эсрэг үйл ажиллагааны олон улсын стандарт ISO 37001 үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлж, баталгаажуулан дотоод зохион байгуулалт, шугаман гурван хяналтын тогтолцоо, эрсдэлд суурилсан дүн шинжилгээ, төлөвлөлт зэрэг ажлуудыг тогтмол хийж байгууллагын соёлын нэг хэсэг болгон хэвшүүлж авлига, ашиг сонирхлын зөрчил, эрсдэл, зөрчилгүй ажиллаж байна.<br>Авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан хаагчдыг аливаа эрсдэлээс хамгаалах, зорилгоор “Эрсдэлийн удирдлагын менежмент”-ийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд дотоод үйл ажиллагаанд процессын дахин инженерчлэл хийж, шат дамжлагыг бууруулан хэлтсийн байцаагч, албан хаагчдын өдөр тутмын ажлын гүйцэтгэлд дотоод хяналт тавих, авлигад өртөх эрсдэл бүхий тэтгэвэр, тэтгэмж бодож, тогтоох байцаагчийг back office буюу арын албанд шилжүүлж, тэтгэвэр тогтоолгож байгаа иргэнтэй шууд харьцахгүй, бүрдүүлсэн материалыг үйлчилгээний хэсэгт шалган авч, тэтгэвэр тогтоогдсоны дараа хариу олгох цэгээр дамжуулан тухайн иргэнд тэтгэврийн дэвтрийг олгодог болсон нь энэ төрлийн гэмт хэрэг, аливаа эрсдэлээс хамгаалах зорилгоор давхар хяналтын системийг нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн өр авлага хариуцсан байцаагчийг эрсдэлээс хамгаалах зорилгоор дуу дүрсний өндөр чанартай бичлэг хийх боломжтой камер бүхий өрөөнд ажиллах боломжийг бүрдүүлэн ажилласан байна.<br>Орхон аймгийн хэмжээнд гомдол, санал, мэдээлэл хүлээн авах 70353511 дугаартай утас мөн Нийгмийн даатгалын хэлтэс | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 75776699 дугаартай утсаар болон цахимаар гомдол мэдээлэл хүлээн авч ажиллаж байгаа бөгөөд Нийгмийн даатгалын хэлтэс нь өөрийн https://ndaatgal.or.gov.mn/ вэб хуудсыг хөгжүүлэн, байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг сайжруулах зорилгоор даатгуулагчдаас өдөр бүр сэтгэл ханамжийн судалгаа авч, үр дүнг тухай бүрт олон нийтэд ил байрлуулдаг ба авлигыг мэдээлэх 110 дугаар болон “Авлигын эсрэг төлөвлөгөө”-г байрлуулан ажиллаж байна.<br>Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д заасны дагуу төсвийн мэдээлэл, мөн Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу холбогдох албан хаагчдын нэр, албан тушаал, холбоо барих хаяг, нийгмийн даатгалын үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрэм, журам, заавар, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн талаарх мэдээ, мэдээлэл үйл явц зэргийг байрлуулан, тухай бүрт шинэчлэн ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| Хэсгийн дундаж хувь *100%* | | | | | |
| Нийт дундаж хувь:100 | | | | | |

Биелэлтийн товчоо

| Д/д | Зорилт арга хэмжээ | Аргаа хэмжээний тоо | Үүнээс | | | | Хэрэгжилтийн тооцох хугацаа болоогүй | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100% биелсэн | Хэрэгжих шатандаа | | | | |
| | | | | 70% | 30% | 0% | | |
| | Засгийн газрын тогтоол | 11 | 11 | | | | | 100% |
| | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 3 | 3 | | | | | 100% |
| | ХНХЯ-ны сайдын тушаал | 4 | 4 | | | | | |
| | НД-ын ҮЗ-ын тогтоол | 2 | 2 | | | | | 100% |
| | НДЕГ-ын даргын тушаал | 28 | 28 | | | | | 100% |
| | НДЕГ-ын даргын албан даалгавар | 1 | 1 | | | | | 100% |
| **Нийт 100%** | | | | | | | | |

ХЯНАСАН:
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРМАНДАХ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН О.ЦОГЗОЛ